



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Тогтоосон хугацаанд хурдан морины
уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 6.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 57 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай" А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүүхдийн эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

2. Өвөл, хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөл байдал морины уралдааны үед үүсэж болох болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, уяач, эцэг, эхчүүдэд сурталчилж ажиллахыг "Хүйн Хурд" морин спорт уяачдын холбоо, 21, 32 дугаар хорооны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Цагдаагийн газар (Г.Байдраг), Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс (Н.Хөхөө), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Д.Хосбаяр)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2025 оны А/59 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

9023100758
9091904 & СБТ23271

